

МОНГОЛ ДАХЬ ЖАЙКА-ИЙН САЙН ДУРЫН ГИШУУД



Japan International Cooperation Agency



Монгол дахь ЖАЙКА-ийн Сайн дурын гишүүд

ЖАЙКА-ийн Сайн дурын гишүүн гэж хэн бэ?

Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА нь 1965-2021 он хүртэл нийт 54418 сайн дурын гишүүнийг дэлхийн 98 оронд ажиллуулаад байна. ЖАЙКА-ийн сайн дурын гишүүд нь хөгжиж буй орны хүсэлтийн дагуу томилогдон ажилладаг ба тухайн орон нутгийн хүмүүстэй хамтран тулгарч буй асуудлыг шийдвэрлэхийг зорьж ажилладаг.

Гол зорилго нь:

- Хөгжиж буй орны эдийн засаг, нийгмийн хөгжил сэргээн босголтод хувь нэмрээ оруулах,
- Өөр соёлтой нийгмийн харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх, хамтдаа хөгжих,
- Сайн дурын гишүүнээр ажилласан туршилагаа ашиглан нийгэмд хувь нэмэр оруулах зэрэг болно.

ЖАЙКА-ийн сайн дурын ажилтны

үйл ажиллагааны салбар

ЖАЙКА-ийн сайн дурын ажилтан нь 9 салбарт, мөн тус тусын салбарыг нийлүүлбэл 190 гаруй мэргэжлээр 2 жилийн хугацаагаар томилогдон ажилладаг.

1. Төлөвлөлт, засаг захиргаа
2. Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур
3. Уул уурхай
4. Хүний нөөц
5. Эрүүл мэнд
6. Нийгмийн халамж
7. Худалдаа, аялал жуулчлал
8. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа
9. Эрчим хүч

ЖАЙКА-ийн Сайн дурын гишүүд

МОНГОЛ УЛСАД



1992 оны 4-р сард ЖАЙКА-ийн анхны сайн дурын залуу 2 гишүүн, 2000 оны 11-р сард анхны сайн дурын ахмад 3 гишүүн томилогдож байсан түүхтэй ба түүнээс хойш 2020 оныг хүртэл нийт 712 ЖАЙКА-ийн Сайн дурын гишүүд Монгол Улсад томилогдон ажилласан байна.

Тэд нийслэл Улаанбаатар хот, 16 аймагт эрүүл мэнд, боловсрол, тусгай хэрэгцээт боловсрол, спорт зэрэг олон салбарт өөрсдийн мэдлэг чадвараа зориулж үр дүнтэй ажиллаж ирсэн. Мөн, Монгол дахь өдөр тутмын амьдрал, үйл ажиллагаагаараа дамжуулан хоёр орны соёл, найрамдалт харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлж байна.

Сайн дурын гишүүний төрөл

Залуу сайн дурын гишүүн(JOCV): Дэлхийд хамгийн урт хугацаанд хэрэгжиж буй сайн дурын хөтөлбөрийн нэг юм. Өөрийн ур чадвараа хөгжиж буй орны хөгжилд оруулах гэсэн чин хүсэлтэй хүмүүс байдаг ба тэднийг ажлын **Төрлөөр** нь сонгодог.

Ахмад сайн дурын гишүүн(SV): Өөрийн ур чадвараа хөгжиж буй орны хөгжилд оруулах гэсэн чин хүсэлтэй хүмүүс байдаг ба тэднийг ажлын **Туршлагаар** нь сонгодог.

Гол 4 салбар



ЭРҮҮЛ МЭНД



Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой олон мэргэжлээр Сайн дурын гишүүнийг илгээн эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг бүхэлд нь сайжруулахыг зорин ажиллаж байна. Тодруулбал, эмчилгээний тогтолцоог бэхжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, өвчтөний асаргаа зэрэг эрүүл мэндийн үйлчилгээний чанарыг бүхэлд нь сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.



БОЛОВСРОЛ



Бага, дунд сургууль, багш бэлтгэдэг боловсролын байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх байгууллага руу Сайн дурын гишүүнийг илгээнээр боловсролын чанар болон багшийн заах аргыг сайжруулахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд “хүүхэд төвтэй сургалт” гэсэн уриатайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛ



Хүртгэмжтэй боловсрол буюу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг энгийн сургууль, цэцэрлэгт хүлээн авдаг болсоноор Сайн дурын гишүүн нь Монгол багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй харьцах арга, заах арга зүйн талаарх мэдлэг, туршлагаа хуваалцаж байна. Хүртгэмжтэй боловсролыг хэрэгжүүлдэг сургууль, цэцэрлэгийн багш нарт семинар, загвар хичээлээр дамжуулан тэдгээр багш ажилтны чадварыг бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг.




АЖ ҮЙЛДВЭР



Аж үйлдвэрийг төрөлжүүлэх зорилгоор жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, аж ахуйн нэгж(Дижитал шилжүүлэг)-д шаардлагатай ИТ салбарын боловсон хүчний чадварыг бэхжүүлэх, аялал жуулчлалын салбарын PR зэрэг аж үйлдвэрийн суурийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг явуулдаг.

ЖАЙКА-ийн сайн дурын томилогдон ажилласан гишүүдийн тоо, бүс нутгаар



Province	Members
Баян-Өлгий аймаг	2
Увс аймаг	6
Хөвсгөл аймаг	8
Завхан аймаг	6
Архангай аймаг	6
Өвөрхангай аймаг	6
Баянхонгор аймаг	5
Говь-Алтай аймаг	5
Ховд аймаг	5
Хөвсгөл аймаг	8
Өмнөговь аймаг	3
Дундговь аймаг	5
Дорноговь аймаг	12
Хэнтий аймаг	11
Төв аймаг	11
Булган аймаг	31
Сэлэнгэ аймаг	27
Орхон аймаг	39
Дархан-Уул аймаг	68
Дорнод аймаг	23
Сүхбаатар аймаг	12
Улаанбаатар хот	441
Говьсүмбэр аймаг	9


ЖАЙКА-ийн Монгол Улс дахь сайн дурын

үйл ажиллагааны товчоон







1991 оны 3 сар	← Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүн(JOVC)-ийг томилон ажиллуулах тухай хэлэлцээр байгуулагдав.
1992 оны 3 сар	← Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүдийн төлөөлөгчийн газар нээгдэж, анхны зохицуулагч ажилтан томилогдов.
1992 оны 4 сар	← Анхны сайн дурын 2 залуу гишүүн томилогдов.
1995 оны 2 сар	← Сайн дурын гишүүн анх удаа орон нутагт томилогдов.
1997 оны 1 сар	← ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар нээгдэв.
1997 оны 7 сар	← Сайн дурын ахмад гишүүн(Senior Volunteers)-ийг томилон ажиллуулах тухай хэлэлцээр байгуулагдав.
2000 оны 11 сар	← Сайн дурын анхны ахмад гишүүн 3 ажилтан томилогдов.
2003 оны 12 сар	← Техникийн хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулагдав.
2005 он	← Томилогдон ажилласан ЖАЙКА-ийн сайн дурын нийт гишүүдийн тоо 300-д хүрэв.
2015 он	← Томилогдон ажилласан ЖАЙКА-ийн сайн дурын нийт гишүүдийн тоо 600-д хүрэв.
2017 оны 3 сар	← Японы далайн чанад дахь сайн дурын залуу гишүүн(JOVC)-ийг томилон ажиллуулсаны 25 жилийн ой болсон.
2019 оны 7 сар	← Томилогдон ажилласан ЖАЙКА-ийн сайн дурын нийт гишүүдийн тоо 700-д хүрэв.
2021 оны байдлаар	← Монголд нийт ЖАЙКА-ийн 712 сайн дурын ажилтан томилогдон ажилласан байна.



2020 оны 9-р сарын байдлаар дэлхийн 98 улсад сайн дурын гишүүд томилогдон ажиллаад байна.



ЖАЙКА-ИЙН МОНГОЛ ДАХЬ ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗРЫН ХАЯГ

-  Бодь Цамхаг 7-р давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Төв шуудан 682
-  +976-11-325939
-  jicamg_volunteer@jica.go.jp
-  <https://www.jica.go.jp/mongolia/mon/index.html>
-  JICA Mongolia
-  JICA Mongolia

